


Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин ба тулгамдсан асуудал



ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТЕХНОЛОГИЙН НЭГДЭН НИЙЛЭЛТ



Ч.ОЮУНГЭРЭЛ
ХХЗХ, Зохицуулалтын
албаны ахлах мэргэжилтэн
2010-11-19



Агуулга

1. Харилцаа холбооны зохицуулах хороо

2. Технологийн хөгжил, нэгдэн нийлэлт

3. Телевизийн өргөн нэвтрүүлгийн зах зээл, өрсөлдөөн

4. Эрх зүйн зохицуулалт



Монгол Улсын харилцаа холбооны салбарын бүтэц, бодлого, зохицуулалтын тогтолцоо

Харилцаа холбооны тухай хууль
/1995 оны 12-р сар /

Харилцаа холбооны тухай хууль
/2001 оны 10-р сарын 1 /





Зохицуулах хорооны бүрэн эрх

Харилцаа холбооны тухай хуулийн 8,9 –р зүйл

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөөний нөхцөл бүрдүүлэх, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах

Харилцаа холбоо = цахилгаан холбоо+мэдээллийн технологи + радио,телевиз + шуудан

1. Тусгай зөвшөөрөл олгох, нөхцөл шаардлага тогтоох, биелэлтэнд нь хяналт тавих
2. Радио давтамжийн хуваарилалт, хяналт
3. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах
4. Дугаарлалтын зохицуулалт
5. Үйлчилгээний чанарын хяналт
6. Сүлжээ хоорондын харилцан холболтын зохицуулалт
7. Үйлчилгээний тарифийн зохицуулалт
8. Стандарт боловсруулах, баталгаажуулалт хийх
9. Маргаан шийдвэрлэх




2. Технологийн хөгжил, нэгдэн нийлэлт




Хөгжлийн гол хүчин зүйлс

Тоон технологи,
Компьютер, интернэт



Олон төрлийн үйлчилгээ,
Контентийн хөгжил



НЭГДЭН НИЙЛЭЛТ



Хөгжлийн хүчин зүйл – Компьютерийн хэрэглээ

Компьютерийг үйлдвэрлэл болон сүлжээнд хэрэглэх хэрэглээ





Хөгжлийн хүчин зүйл – Интернэтийн сүлжээ

Интернетэд үйлчилгээ маш олон төрлийн болон хөгжиж байна.






Мэдээллийн технологийн үйлчилгээ- нийгмийн бүх салбарт


Технологийн өөрчлөлт -> нийгэм эдийн засагт

Үр ашигтай, хурдан шуурхай, чанартай
e-банк, e-эрүүл мэнд, e-засаглал, e-сургалт
& бүх төрлийн e-үйлчилгээ
e-дэлгүүр



Дараа үеийн сүлжээний дэвшилтэт хөгжил

Ubiquitous сүлжээ



- ✓ *Өртөгөөр хямд, хамрах хүрээ өргөн*
- ✓ *Хөрөнгө оруулалт бага, богино хугацаанд нөхөх боломжтой*
- ✓ *Шинэ компани орох боломжтой*




Нэгдэн нийлэлт

- Нэгдэн нийлэлт гэж юу вэ?
 - Ялгаатай технологиор дамжин олон төрлийн үйлчилгээг хэрэглэгч нэг төхөөрөмжөөр хүлээн авах боломж

“Нэгдэн нийлэлт бол зөвхөн технологи биш. Энэ нь шинэ үйлчилгээний тухай бөгөөд бизнесийн болон нийгэмтэй харилцах шинэ боломж юм”




Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба нэгдэн нийлэлт



- ▶ Технологийн хөгжил → Тогтвортой хөгжлийн төлөв
- ▶ Үйлдвэрлэлийн хөгжил → Хэт их мэдээлэл → Үр ашигтай мэдээллийг олж авах



Технологийн хөгжил






3. Телевизийн өргөн нэвтрүүлгийн зах зээл, өрсөлдөөн



Зах зээлийн бүтэц





Зах зээл дэх өрсөлдөөн – олон улсад

**Өргөн нэвтрүүлгийн
телевизийн зах зээл**

(Рекламны зах зээл)

Хэрэглэгчээс төлбөр авдаггүй

Үндсэн санхүүжилт нь Реклам, зар сурталчилгаа

Контент бэлтгэдэг

**Олон сувагт
телевизийн зах зээл**

**КаТВ
Хиймэл дагуулын ТВ
АйПиТВ
Мобайл ТВ**

Үндсэн санхүүжилт нь хэрэглэгчийн хураамж

Контент бэлтгэхгүй



Зах зээл дэх өрсөлдөөн - Монголд



Хэрэглэгчээс төлбөр авдаггүй

Үндсэн санхүүжилт нь Реклам, зар сурталчилгаа

Контент бэлтгэдэг

Санхүүжилт нь хэрэглэгчийн хураамж + зар сурталчилгаа + сувгийн түрээс

Өөрийн эзэмшлийн сувгаар контент бэлтгэн дамжуулна



4. Эрх зүйн зохицуулалт



Ямар эрх зүйн баримт бичгээр зохицуулдаг вэ?

Олон улсад



Олон улсын гэрээ, конвенц	✓ НҮБ-ийн хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946 ✓ Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, 1966 он ✓ Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын конвенц, 1950 он ✓ Хил дундын телевизийн тухай Европын конвенц, 1989 он	✓ НҮБ-ийн хүний эрхийн түгээмэл тунхаглал ✓ Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, 1974 ✓ Зохиогчийн эрхийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ (1996) - 2002
Хууль	✓ Үндсэн хууль ✓ Хэвлэл мэдээллийн тухай ✓ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль ✓ Электроник медиагийн тухай хууль ✓ Бусад холбогдох хуулиуд (өрсөлдөөний, зар сурталчилгааны, сонгуулийн, хүүхдийн эрхийн, зохиогчийн эрхийн)	✓ Үндсэн хууль ✓ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай ✓ Харилцаа холбооны тухай хууль ✓ Бусад холбогдох хуулиуд <i>Олон нийтийн радио, телевизийн тухай хууль</i> <i>Зар сурталчилгааны тухай хууль</i> <i>Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хууль</i> <i>Архиван согтуурахтай тэмцэх тухай хууль</i> <i>Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль</i> <i>Сонгуулийн тухай хуулиуд</i>
Код	Нэгдсэн үйл ажиллагааны код, Ёс зүйн код	Байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрэм
Журам, нөхцөл шаардлага	Тусгай зөвшөөрөл олгох ангилал, ил тод тодорхой процедур, нарийвчилсан нөхцөл шаардлага	Журмаар зохицуулах тухай Засгийн газрын чиглэл /2010-10-27, 276 дугаар тогтоол/ Тусгай зөвшөөрөл олгох ерөнхий журам, ерөнхий нөхцөл шаардлага



Хэн зохицуулдаг вэ?

Олон улсад	 Монголд
Тусдаа өргөн нэвтрүүлгийн бие даасан зохицуулах байгууллага Эсвэл мэдээлэл холбоо, өргөн нэвтрүүлгийн нэгдсэн зохицуулах байгууллага	 Харилцаа Холбооны Зохицуулах Хороо Харилцаа холбоо = цахилгаан холбоо+мэдээллийн технологи + радио,телевиз + шуудан
Өргөн нэвтрүүлгийн холбоо/ телевизүүдийн холбоо/ радиоогийн холбоо/ Self regulation Ёс зүйн дүрэм	Телевизүүдийн холбоо ? КаТВ-үүдийн холбоо ? ФМ-үүдийн холбоо ?



Юуг зохицуулдаг вэ ?

Бид юуг зохицуулж байна

Олон улсад	Одоо 	Ойрын хугацаанд
Тусгай зөвшөөрөл олгох	✓ 	Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг шинэчлэх төсөл , хэлэлцүүлэг
Радио давтамж хуваарилах, олгох	✓ 	
Техникийн стандарт, чанарын шаардлага	✓ 	Шаардлагатай нэмэлт стандартыг боловсруулах
Эзэмшлийн ил тод байдал		ЗГ-ын чиглэлд тусгагдсан
Хувь эзэмшлийн хязгаарлалт - Гадаадын , - улс төр, - төвлөрөлт		ЗГ-ын чиглэлд тусгагдсан
Контент шаардлагууд, нийтийн эрх ашгийг илэрхийлсэн хязгаарлалтууд - үндэсний нэвтрүүлгийн хамгийн бага цаг - зар сурталчилгааны хязгаарлалт - үндэсний цөөнхөд зориулсан нэвтрүүлэг заавал байх - хөтөлбөрийн ангилал, рэйтинг, цагийн хязгаарлалт - сонгуулийн үеийн хөтөлбөрийн доод хэмжээ	Зарим хуулиудаар зохицуулагдсан.	ЗГ-ын чиглэлд тусгагдсан
Ёс зүйн дүрэм - үйлчилгээ эрхлэгчдийн холбоод өөрсдөө гарган мөрдөж, хариуцлага тооцдог.		Телевизүүд хамтран Телевизийн ёс зүйн дүрэм боловсруулах Телевизүүдийн холбоо, ННФ – ОУ зөвлөх



Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл

- Засгийн газрын 2010-10-27 өдрийн 276 дугаар тогтоолоор ХХЗХ-нд дараах үүрэг өгөгдсөн:
- Телевиз радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэлийн дагуу телевизийн нэвтрүүлэгт тавигдах нөхцөл, шаардлагыг шинэчлэн тогтоож, телевиз, радиогийн зохицуулалтын журмыг 2010 онд багтаан баталж, мөрдүүлэх
- Телевизийн үйл ажиллагаанд мөрдөх мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэхэд Монголын телевизүүдийн холбоонд зохих дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах.



Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл

1. Телевиз, радиогийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн түгээмэл тунхаглалд нийцсэн байх.
2. Телевизийн хөрөнгө оруулагч, эзэмшигч, удирдлагын талаархи мэдээллийг олон нийтэд ил тод болгох.
3. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.2.2-т заасан чиглэлийг баримталж ажиллах.

3.2.2.2. Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.

4. Оюуны өмчид хамаарах Монгол Улсын олон улсын гэрээ, конвенци болон хууль тогтоомжийг мөрүүлэх.
5. Телевиз, радиогийн үйл ажиллагаанд мөрдөгдөх мэргэжлийн ёс зүйн дүрэм, түүнийг хэрэгжүүлэх өөрийн зохицуулалтын байгуулагатай байхыг дэмжих.
6. Хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхдээ эдийн засгийн механизмыг үндсэн хэрэгсэл болгох.



Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл

7. Телевиз, телевизийн студи, кабелийн телевизийг тодорхойлж, нэгдсэн ойлголттой болж, тэдгээрт тавих стандартыг ялгаатай тогтоож мөрдүүлэх
8. Телевизэд тусгай зөвшөөрөл олгохдоо нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүйг нь үндэсний эрх ашиг, соёл, хэл, зан заншил, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, Монгол Улсад бүтээсэн бүтээл байх зохицуулалтыг гэрээнд тусгаж байх.
9. Олон нийтийг хүчирхийлэл, садар самуун, гүтгэлэг, худал мэдээллээс хамгаалах, хүний хувийн нууцыг хадгалах талаар стандарт, журам тогтоох
10. Онцгой байдал үүссэн нөхцөлд шаардлагатай зар мэдээллийг олон нийтэд үнэ төлбөргүй, шуурхай хүргэх асуудлыг зохицуулах.



Анхаарах зүйлс, хийгдэх ажлууд

- Үйлчилгээ эрхлэгчид, олон нийтийн төлөөллийг оролцуулсан журмын төсөл, нөхцөл шаардлага боловсруулах ажлын хэсэг байгуулах
- Журмын төслөөр үйлчилгээ эрхлэгчид, олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийх
- Хэрэгжүүлэх механизмд анхаарах



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА



www.crc.gov.mn